



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/49

Мандалговь

**Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг
даатгалд хамруулах тухай**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай 2019 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг гэнэтийн ослын эрсдэл болон бүх төрлийн хүчирхийллийн эрсдэлийг багтаасан даатгалын цогц үйлчилгээнд хамруулах зорилгоор улсын хэмээнд зохион байгуулагдаж байгаа ажлын хүрээнд орон нутгийн мэдээллийн санд бүртгэлтэй 1435 хүүхдүүдийн 20%-ийг даатгалын цогц үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллахыг Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Мөнхсаруул)-д даалгасугай.

2. Даатгалын үйл ажиллагаанд шаардагдах 2.152.500 (Хоёр сая нэг зуун тавин хоёр мянга таван зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Хүүхдүүдийг даатгалд хамруулах ажлыг 2019 оны 07 дугаар сарын 16-25-ны өдрүүдэд зохион байгуулж тайланг даргын дэргэдэх зөвлөлд 2019 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ